



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 сарын 21 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛЭГ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь санхүүгийн зах зээлийн зохистой хөгжлийг дэмжих хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд үзүүлэх мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль тогтоомж

2.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль тогтоомж нь Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг болон зээлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Хуульд заасны дагуу хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд /цаашид "харилцагч" гэх/-д үзүүлэх мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.үйл ажиллагааны нууцлал, аюулгүй, найдвартай байдлыг хангах;
- 4.1.2.харилцагчид үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, зөвлөгөөг өгч, ил тод байдлыг хангах;
- 4.1.3.талуудын тэгш оролцоог хангах;
- 4.1.4.хувийн ашиг сонирхлоо харилцагчийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй байх;
- 4.1.5.хууль тогтоомжид заасан шаардлага хангасан харилцагчид үйлчилгээ үзүүлэх.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 5.1.1."зээл" гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр хүүтэй буюу хүүгүй бусад этгээдэд аливаа хэлбэрээр олгосон мөнгөн хөрөнгийг;

5.1.2."Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд" гэж хуулиар тусгайлан эрх, үүрэг нь тодорхойлогдож, хариуцлага хүлээдэг этгээдийг;

5.1.3."мөнгөн хадгаламж" гэж гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдээс банк, эрх бүхий хуулийн этгээдэд хадгалуулсан үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг болон гадаад улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх мөнгөн хөрөнгийг;

5.1.4."үйл ажиллагааны ерөнхий нөхцөл" гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд үзүүлэх мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтыг тусгасан баримт бичгийг;

5.1.5."харилцах данс" гэж гэрээний үндсэн дээр банк, цахим мөнгө гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр нээсэн дансыг;

5.1.6."хүү" гэж гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр буюу үнийг;

Тайлбар: Зээл, хадгаламжийн үнэ бөгөөд хөрөнгө эзэмшигчийн хувьд орлого, ашиглагчийн хувьд зардлыг ойлгоно.

5.1.7."шилжүүлэг" гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д заасныг;

5.1.8."эрх бүхий хуулийн этгээд" гэж хуульд заасны дагуу Монголбанкнаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;

5.1.9."эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.

6 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдээс мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйлчилгээ үзүүлэх журам

6.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хадгаламж /цаашид "хадгаламж" гэх/, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг /цаашид "шилжүүлэг" гэх/, зээлийн үйл ажиллагаанд баримтлах энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг нийтэд ил тод мэдээлнэ.

6.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчид хадгаламж, зээлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлнэ.

6.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 6.2-т заасны дагуу гэрээ байгуулахдаа харилцагчийг тухайн үйлчилгээний болон гэрээний нөхцөлтэй танилцах боломж, нөхцөлөөр хангана.

6.4.Энэ хуулийн хоёрдугаар бүлгээс дөрөвдүгээр дүгээр бүлэгт заасан үйл ажиллагааг зөвхөн хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан банк, эрх бүхий хуулийн этгээд эрхэлнэ.

6.5.Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй.

6.6.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

6.7.Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс тогтоосон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг бууруулахыг санал болгох, саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох бөгөөд энэ тухайгаа нийтэд мэдээлэх эрхтэй байна.

6.8.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуульд заасан үйлчилгээний гэрээ байгуулах бүх үе шатанд "харилцагчийн нууц" гэж үзсэн мэдээллийг хадгалах, аливаа хэлбэрээр ашиглахгүй байх үүрэгтэй.

7 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх

7.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ.

7.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээдэд цахим хэлбэрээр аливаа данс нээхийг хориглоно.

8 дугаар зүйл.Үйл ажиллагааны ерөнхий нөхцөл

8.1.Энэ хуульд заасан банк, эрх бүхий хуулийн этгээдийн хадгаламж болон зээл, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн шилжүүлгийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд батална.

8.2.Энэ хуульд заасан үйл ажиллагааны ерөнхий нөхцөлд банк, эрх бүхий хуулийн этгээдээс харилцагчид үзүүлэх хадгаламж,

шилжүүлэг, зээлийн үйлчилгээний нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны журмыг тусгасан байна.

9 дүгээр зүйл.Хадгаламж, харилцах, зээлийн данс нээх, хаах

9.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаа эрхлэхдээ харилцагчид Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан баримт бичиг, журмыг баримтлан хадгаламж, харилцах, зээлийн данс нээж үйлчилгээ үзүүлнэ.

9.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд хуульд заасны дагуу иргэнд данс нээхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.2.1.хүсэлт;

9.2.2.мөнгөн хөрөнгө захиран зарцуулах этгээдийн төлбөрийн баримтад зурах гарын үсгийн маяг;

9.2.3.эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

9.2.4.хуульд заасан бусад.

9.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд данс нээхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.3.1.хүсэлт;

9.3.2.дүрэм, түүнтэй адилтгах баримт бичиг;

9.3.3.тамга, тэмдгийн дардас;

9.3.4.мөнгөн хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр төлбөрийн баримтад зурах гарын үсгийн маяг. Гарын үсгийн маяг нь нотариатаар гэрчлүүлсэн байх;

9.3.5.эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

9.3.6.хуульд заасан бусад.

9.4.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд болон гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд тэдгээрийг хянан зохицуулж байгаа эрх бүхий этгээдээс тамга, тэмдэг хэрэглэх шаардлага тавьдаггүй тохиолдолд энэ хуулийн 9.3.3 дахь заалт хамаарахгүй.

9.5.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн харилцагчид хадгаламж, харилцах болон зээлийн данс дахин нээх тохиолдолд тухайн харилцагчийн баримт бичигт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг шинэчлэн авах үүрэгтэй.

9.6.Харилцагч энэ хуулийн 9.5-д заасан мэдээллийг өгөхөөс татгалзсан бол үйл ажиллагааны ерөнхий нөхцөлд заасны дагуу банк, эрх бүхий хуулийн этгээд нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, дансыг хаах, холбогдох гэрээг цуцлах үүрэгтэй.

9.7.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9.2, 9.3-т заасан баримт бичгийг хянан үзээд ажлын таван өдрийн дотор данс нээх, эсхүл эдгээр баримт бичиг хуульд заасан шаардлага хангаагүй бол данс нээхээс татгалзана.

9.8.Банк дараах тохиолдолд дансыг хааж болно:

9.8.1.харилцагч данс хаалгах хүсэлт гаргасан;

9.8.2.харилцагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцөл биелэгдсэн;

9.8.3.энэ хуулийн 9.6-д заасан нөхцөл бүрдсэн;

9.8.4.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.9.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн харилцагчийн техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан илэрхийлсэн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 7.3-т зааснаас бусад тохиолдолд цахим хэлбэрээр данс нээж, хааж болно.

9.10.Аливаа дансан дахь мөнгөн хөрөнгийн талаарх мэдээллийг бусдыг хуурч мэхлэх, хуурамч тодорхойлолт гаргах зорилгоор ашиглахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

10 дугаар зүйл.Мөнгөн хадгаламж

10.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд /цаашид "хадгалагч" гэх/-ээс иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд /цаашид "хадгалуулагч" гэх/-д Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан журам болон энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг баримтлан гэрээ байгуулж, хадгаламжийн үйлчилгээ үзүүлнэ.

10.2.Хадгалагч нь хадгалуулагчтай хадгаламжийн гэрээ байгуулахдаа өөрийн үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв мэдээллийг өгнө.

10.3.Хадгалагч нь өөрийн хадгаламжийн үйлчилгээний нөхцөл, эдгээр үйлчилгээг авч байгаа хадгалуулагчийн гэрээгээр хүлээсэн

эрх, үүргийг тэдгээрт ойлгомжтой байдлаар танилцуулна.

11 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээ

11.1. Иргэний хуулийн 454.1-д заасны дагуу хадгаламжийн гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчийн хадгаламжийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.

11.2. Хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, хүү тооцох журам, гэрээ цуцлах, хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйгээс талуудын хүлээх хариуцлагыг заана.

11.3. Хадгалагч нь хадгалуулагчтай байгуулах хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу цахим хэлбэрээр байгуулж болно.

11.4. Цахим хэлбэрээр байгуулах хадгаламжийн гэрээ нь хадгалуулагч хүсэл зоригоо илэрхийлэн цахим баримт бичиг үйлдэж, цахим гарын үсэг зурж илгээснийг хадгалагч хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

12 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа

12.1. Хадгаламжийн гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна.

12.2. Тодорхой хугацаа зааж хадгалуулсан хадгаламжийг хугацаатай, тодорхой бус хугацаагаар хадгалуулсан хадгаламжийг хугацаагүй хадгаламж гэж тооцно.

12.3. Хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол уг хугацаа дууссаны дараа хадгалагч нь хадгалуулагчийн мөнгийг буцаан өгч, гэрээнд заасны дагуу хүү төлөх үүрэгтэй.

12.4. Хугацаатай хадгаламжийн гэрээг тохиролцсон хугацаанаас өмнө хадгалуулагчийн хүсэлтээр цуцлах, эсхүл зарлагын гүйлгээ хийх тохиолдолд хадгалуулсан хугацаанаас нь хамааруулан хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулна.

12.5. Хадгалагч хугацаагүй хадгаламжийн гэрээг зөвхөн иргэнтэй байгуулна.

12.6. Хадгаламжийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсхүл гэрээг дахин сунгуулах хүсэлт тавиагүй бол хадгалагч дараах арга хэмжээг авна:

12.6.1. иргэний хадгаламжийг хугацаагүй хадгаламжид тооцож, хүүг хугацаагүй хадгаламжийн адил хэмжээгээр бодох;

12.6.2. хуулийн этгээд болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдийн хадгаламжийн дансыг гэрээнд заасан харилцах дансанд шилжүүлэх.

12.7. Хугацаатай хадгаламжийн гэрээг хадгалагч нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас өмнө цуцлах эрхгүй.

12.8. Хадгалуулагч нь хадгалагчаас энэ хуулийн 12.3, 12.7-д заасан үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

12.9. Хадгаламжийн дансыг харилцах дансны зориулалтаар ашиглахгүй бөгөөд аливаа төлбөрийн хэрэгсэлтэй холбож үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

12.10. Хадгаламж, зээлийн хоршооноос энэ хуулийн 12.6-д заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

13 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн хүү

13.1. Хадгалагч хуульд заасны дагуу хадгаламжийн хүү болон бусад нөхцөлийг нийтэд ил тод зарлах бөгөөд ийнхүү зарласан хүү, нөхцөлөөс аливаа хэлбэрээр өөрөөр тогтоон хадгалуулагчтай гэрээ байгуулахыг хориглоно.

13.2. Хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ нь хадгаламжийн гэрээнд өөрөөр заасан, эсхүл хадгалуулагчаас хадгаламжийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан, хадгаламжийн данснаас хуульд заасан үндэслэлээр зарлагын гүйлгээ хийснээс бусад тохиолдолд анх тохиролцсон хэвээр байна.

13.3. Хугацаагүй хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалагчаас өөрчлөх тохиолдолд энэ тухай нийтэд мэдэгдсэнээс хойш нэг сарын дараа хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдсөнд тооцох бөгөөд хүүгийн хэмжээг өөрчилснөөс хойших хугацаанд хийсэн аливаа орлогын тухайд хадгалагчаас өөрчлөн тогтоосон хэмжээгээр хүүг тооцно.

13.4. Энэ хуулийн 13.3-т заасны дагуу өөрчлөлт орсон хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалуулагч зөвшөөрөхгүй тохиолдолд нэмж хийсэн орлогын тухайд хадгалуулахаас татгалзаж болно.

13.5. Хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

14 дүгээр зүйл. Хадгалуулагч, хадгалагчийн эрх, үүрэг

14.1. Хадгалуулагч дараах эрх, үүрэгтэй:

14.1.1. хадгалуулсан мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах хэлбэрийг сонгох;

14.1.2. хадгалуулсан мөнгөн хөрөнгөд хадгаламжийн хүүгийн орлого авах;

- 14.1.3. хадгаламжийн гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулга болон холбогдох бусад баримттай тулган шалгах;
 - 14.1.4. Хадгаламжийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгаламжийг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох;
 - 14.1.5. хадгаламжийг өвлүүлэх, гэрээслэх;
 - 14.1.6. хадгаламжийг бэлэглэх;
 - 14.1.7. хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 14.1.8. хадгаламжийг барьцаалуулах;
 - 14.1.9. хууль, хадгаламжийн гэрээнд заасан бусад эрх, үүрэг.
- 14.2. Хадгалагч дараах эрх, үүрэгтэй:
- 14.2.1. хадгалуулагчийн нэр дээр данс нээж хадгаламжийн дэвтэр, эсхүл хадгаламжийн сертификат олгох;
 - 14.2.2. хуульд өөрөөр заагаагүй бол хадгалуулагчийн хадгаламжаас зөвхөн түүний зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх;
 - 14.2.3. хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар хадгаламжийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хадгаламжийн хүү төлөх;
 - 14.2.4. хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох;
 - 14.2.5. хуульд өөрөөр заагаагүй бол хадгалуулагч болон гуравдагч этгээд "нууц" гэж үзсэн мэдээллийг бусдад аливаа хэлбэрээр гаргаж өгөхгүй, задруулахгүй, ашиглахгүй байх;
 - 14.2.6. мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
 - 14.2.7. өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;
 - 14.2.8. хууль, хадгаламжийн гэрээнд заасан бусад эрх, үүрэг.
- 14.3. Хадгалагч нь хадгаламжид авсан мөнгөн хөрөнгийг өөрийн гүйлгээнд хэрэглэн түүний бүрэн бүтэн байдлыг хангана.

15 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн данс

- 15.1. Хадгалагч нь хадгалуулагч тус бүрд хадгаламжийн данс нээнэ.
- 15.2. Хадгалуулагч нь хадгаламжийн сертификат авсан бол энэ хуулийн 15.1-д заасан данс нээхгүй байж болно.

16 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжид холбогдох гүйлгээний талаарх зохицуулалт

- 16.1. Хадгалуулагч нь хадгаламжийн орлого, зарлагын гүйлгээг бичгээр олгосон итгэмжлэл бүхий төлөөлөгчөөр дамжуулан хийлгэж болно. Хадгалагч хуульд заасан шаардлага хангасан хүчин төгөлдөр итгэмжлэл, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хуульд заасан бичиг баримтыг үндэслэн гүйлгээ хийнэ.
- 16.2. Хадгалуулагч нас барсан, эсхүл нас барсан гэж зарлагдсан тохиолдолд хадгалагч хадгаламжийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлах эрх бүхий этгээдэд олгох, эсхүл тухайн хадгаламжийн гэрээг түүний нэр дээр шинэчлэн хийж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МӨНГӨН ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

17 дугаар зүйл. Мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх

- 17.1. Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчтай байгуулсан гэрээ, түүний даалгавар, зөвшөөрлийг үндэслэн шилжүүлгийг хийнэ.
- 17.2. Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчийн шилжүүлгийг төлбөрийн даалгаврыг шалгасны үндсэн дээр харилцагчийн мөнгөн хөрөнгийн дүнд багтаан хийнэ.
- 17.3. Төлбөрийн даалгавар нь бичгийн болон цахим хэлбэртэй байж болно.
- 17.4. Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас хүлээн авсан төлбөрийн даалгаврыг хуульд өөрөөр заагаагүй бол хүлээн авсан дэс дарааллыг баримтлан Монголбанкнаас баталсан журамд заасан хугацаанд шилжүүлгийг хийнэ.
- 17.5. Банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх хадгаламж, зээл, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээ нь бэлэн болон бэлэн бус хэлбэртэй байж болно.
- 17.6. Шилжүүлгийг хуульд заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрсөн биет, биет бус төлбөрийн хэрэгслээр хийж болно.
- 17.7. Төлбөрийн нэхэмжлэлээр хийх төлбөрийг гагцхүү төлбөр хариуцагчийн мөнгөн хөрөнгийг зарцуулах эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Векселиэр хийх шилжүүлгийг Векселийн тухай хуулиар зохицуулна.
- 17.8. Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн алдаатай хийсэн аливаа шилжүүлгийг залруулж, харилцагчийг хохиролгүй болгоно.

17.9.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 17.4-т заасан хугацаанд шилжүүлгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хийгээгүйгээс үүссэн хохирлыг хариуцна.

17.10.Харилцагчийн хүсэлтээр банк, эрх бүхий хуулийн этгээд нь гүйлгээ хийсэн дансны хуулгыг харилцагчид өгнө.

17.11.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанк төлбөрийн даалгавар, шилжүүлэгтэй холбогдсон харилцааг зохицуулах журам, заавар баталж, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

18 дугаар зүйл.Харилцах данс, харилцах дансны дэд эзэмшигч

18.1.Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

18.2.Харилцах данс нь данс эзэмшигч, дансны дэд эзэмшигчтэй байж болно.

18.3.Харилцах данс эзэмшигчээс олгосон эрхийн хүрээнд харилцах данснаас данс эзэмшигчийн эрхийг хязгаартайгаар хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг харилцах дансны дэд эзэмшигч гэнэ.

18.4.Харилцах дансны дэд эзэмшигч нь харилцах данс эзэмшигчээс хуульд заасны дагуу олгосон итгэмжлэлийн хүрээнд харилцах данснаас зарлагын гүйлгээ хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

19 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа

19.1.Зээлийн ашигласан хугацаа нь зээлдүүлэгчээс зээлдэгчид гэрээнд тохиролцсон хэлбэрээр зээл олгосноор эхэлж, зээлдэгч зээлдүүлэгчид буцаан төлснөөр дуусгавар болно.

19.2.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

19.3.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.

19.4.Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийг зээлжих эрх, зээлийн карт, зээлийн шугам зэрэг хэлбэрээр, техникийн хэрэгсэл, программ хангамж ашиглан олгож болно.

19.5.Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно.

19.6.Зээл олгох хэлбэрийг зээлдэгч, зээлдүүлэгч нь зээлийн гэрээндээ харилцан тохиролцоно.

19.7.Зээлдүүлэгч гадаад валютаар зээл хүссэн зээлдэгчид ханшийн эрсдэлийн талаарх зөвлөмж, мэдээллийг өгнө.

19.8.Зээлийг зээлийн гэрээнд заасан зориулалтаар нь ашиглах бөгөөд олгосон зээлийн ашиглалтыг зээлдүүлэгч шалгаж, зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд зээлийн гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, олгосон зээлийг нэн даруй буцаан зээлдэгчээс төлөхийг шаардана.

19.9.Зээлдэгч барьцаат зээлээ төлсөн, эсхүл хууль, зээлийн гэрээнд заасны дагуу зээлийн гэрээний үүрэг дуусгавар болсон тохиолдолд зээлдүүлэгч зээлдэгчийн зээлийн дансыг хааж, зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлж, энэ тухай эрхийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

19.10.Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

19.11.Банкнаас олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

19.12.Гадаад валютын орлогын эх үүсвэртэй, эсхүл ханшийн эрсдэлээс хамгаалагдсан этгээдэд гадаад валютын зээл олгож болно.

19.13.Зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болохоор, эсхүл болсон бол зээлдүүлэгч зээл олгохоос татгалзах, эсхүл олгосон зээлийг буцаан төлөхийг шаардах эрхтэй.

19.14.Зээлдэгч хуулийн этгээд нь олгосон зээлийг өөрийн санхүүгийн тайланд тусгаж, энэ талаарх мэдээллийг зээлдүүлэгчид өгөх үүрэгтэй. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд хуулиар санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол түүнд энэ хэсэг нэгэн адил хамаарна.

19.15.Зээлдүүлэгч анх зээл олгохдоо зээлдэгчээр зээлийн хүүг урьдчилан төлүүлэхийг хориглоно.

19.16.Зээлдүүлэгч нь баталгаа гаргагчтай Иргэний хуулийн 234 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу гэрээ байгуулна.

20 дугаар зүйл.Зээлийн гэрээ

20.1.Иргэний хуулийн 451.1-д заасны дагуу зээлийн гэрээгээр банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь зээлийн гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, зээлийн гэрээнд заасан бол хүүг буцаан төлөх үүргийг хүлээнэ.

20.2.Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна:

20.2.1.зээлийн хэмжээ;

20.2.2.мөнгөн тэмдэгтийн төрөл;

20.2.3.зээлийн дансны дугаар;

20.2.4.зээлийн зориулалт, зээл олгох хэлбэр;

20.2.5.зээлийн гэрээний хугацаа;

20.2.6.зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл;

20.2.7.зээлийн хүүгийн хэмжээ;

20.2.8.зээлийн гэрээнд оролцогч талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаяг;

20.2.9.тохиролцсон бол үүргийн гүйцэтгэлийг хангах арга, хэлбэр;

20.2.10.гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах нөхцөл;

20.2.11.зээлдүүлэгч, зээлдэгчийн эрх, үүрэг, хариуцлага;

20.2.12.хуулиар хориглоогүй шаардлагатай бусад зүйл.

20.3.Зээлийн гэрээний хугацаа дууссан нь тухайн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

20.4.Энэ хуулийн 19.8-д заасан нөхцөл байдал үүссэн нь зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

20.5.Тодорхой төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр олгох зээлийн эх үүсвэрийг зээлдүүлэгчид хамтран гаргаж болно. Хамтран зээл олгохдоо энэ талаар гэрээ байгуулна.

20.6.Засгийн газрын мэдлийн гадаад эх үүсвэр, олон улсын байгууллагын хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх зээлийн харилцааг зээлдэгч болон Засгийн газар, шилжүүлэг гүйцэтгэгч банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

20.7.Зээлийн гэрээнд зээлдэгчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээдийг хамтран зээлдэгч гэнэ.

20.8.Зээлийн гэрээнд зааснаар гэрээний үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээх үүрэг бүхий этгээдийг хамтран үүрэг гүйцэтгэгч гэнэ.

21 дүгээр зүйл.Зээлийн хүү

21.1.Зээлийн хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцно.

21.2.Зээлдэгч зээлийг зээлийн гэрээнд заасны дагуу төлөөгүй, эсхүл хууль, зээлийн гэрээнд заасан үндэслэлээр зээлдүүлэгчийн нэг талын санаачилгаар зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан бол зээлийг бүрэн эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд зээлийн үндсэн хүү, зээлийн гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө.

21.3.Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

22 дугаар зүйл.Зээлийн хувийн хэрэг

22.1.Зээлдүүлэгч нь олгосон зээл бүрдээ зээлийн хувийн хэрэг нээж хөтөлнө.

22.2.Зээлийн хувийн хэрэг дараах бүрдүүлбэртэй байна:

22.2.1.зээл олгохыг хүссэн өргөдөл;

22.2.2.зээлийн гэрээ;

22.2.3.зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар сонгосон арга хэлбэр, түүнтэй холбогдох мэдээлэл;

22.2.4.иргэн бол орлогын талаарх мэдээлэл;

22.2.5.хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бол орлогын талаарх мэдээлэл, хуульд заасны дагуу татварын байгууллагад тайлагнасан санхүүгийн тайлан;

22.2.6.зээл хүсэгчийн өр, орлогын харьцааг нотолсон баримт бичиг;

22.2.7.зээлийн ашиглалтыг шалгасан материал;

22.2.8.зээлдэгчийн бусад зээлдүүлэгчээс авсан зээл, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл;

22.2.9.үйл ажиллагааны ерөнхий нөхцөлд заасан болон зээлдүүлэгчээс зээл олгоход шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, баримт бичиг.

22.3.Энэ хуулийн 19.11-д заасан журмын дагуу зээлийн үүргийн гүйцэтгэлд барьцаалах эд хөрөнгийн тодорхойлолтод зээлдэгчээс барьцаалж байгаа эд хөрөнгийг зээлдүүлэгч, эсхүл түүнээс томилогдсон хөрөнгийн үнэлгээчин газар дээр нь очин, нэг бүрчлэн үзэж өгсөн үнэлэлт, дүнг тусгасан байна. Зээлийн үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгийг шалгасан баримтад дээрх тодорхойлолтыг үндэслэн тухайн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэ, чанар зэргийг бичнэ.

22.4.Зээлийн баталгаа гаргагч, батлан даагчийн бүртгэлд баталгаа гаргагч, батлан даагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг харилцагч банкны нэр, харилцах дансны дугаар зэргийг тусгана. Баталгаа гаргагч, батлан даагчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, үйл ажиллагааны талаар зээлдэгчийн адил судалж тэмдэглэсэн байна.

22.5.Зээлийн ашиглалтыг шалгасан баримт бичигт авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж байгаа эсэхийг тодорхой тоо хэмжээ, үнийн дүн зэрэг үзүүлэлтээр энэ хуулийн 19.10, 19.11-д заасан журмын дагуу тодорхойлж бичнэ.

22.6.Зээлдүүлэгч нь зээлдэгчээс зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоос бусад баримт бичиг, мэдээлэл шаардахыг хориглоно. Энэ хэсэгт хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд шаардах баримт бичиг, мэдээлэл хамаарахгүй.

23 дугаар зүйл.Зээлийн батлан даалт

23.1.Зээлдэгч нь авсан зээл, түүний хүүг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлж чадахыг зээлдүүлэгчийн өмнө баталж, хэрэв төлж чадахгүй бол түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх үүргийг гуравдагч этгээд хүлээхийг зээлийн батлан даалт, батлан даалт гаргасан этгээдийг батлан даагч гэнэ.

23.2.Зээлдэгч нь Иргэний хуульд заасан шаардлагын дагуу батлан даагчтай гэрээ байгуулна.

23.3.Батлан даагч хүлээсэн үүргээ хууль, гэрээнд заасны дагуу биелүүлж, зээлдэгчийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.

23.4.Батлан даагч, баталгаа гаргагч нь санхүүгийн хувьд уг зээлийн төлбөрийн үүргийг гүйцэтгэх чадвартай, эд хөрөнгөтэй этгээд байна. Батлан даагч, баталгаа гаргагчийн санхүүгийн чадварын талаар харилцагч банк, эрх бүхий хуулийн этгээд, эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн байгууллага нь тодорхойлолт гаргаж болно.

23.5.Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр буюу батлан даагч зээлдэгчийн өмнөөс хүлээсэн үүргээ биелүүлснээр батлан даалт дуусгавар болно.

24 дүгээр зүйл.Зээлийн барьцаа

24.1.Зээлийн барьцаатай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.

25 дугаар зүйл.Зээлийг хугацаанаас өмнө буцаан төлөх

25.1.Зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэж болно.

25.2.Зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэсэн тохиолдолд зээлийн гэрээ дуусгавар болно.

26 дугаар зүйл.Зээл төлүүлэх

26.1.Зээлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу зээлийг эргүүлэн төлөх үүргийг зээлдэгч хүлээнэ.

26.2.Гэрээнд заасан бол зээл, зээлийн хүүг төлөх хугацаа болмогц зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч, баталгаа гаргагч, батлан даагчийн дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлүүлнэ.

27 дугаар зүйл.Зээлийг ангилах

27.1.Зээлдүүлэгч олгосон зээлдээ судалгаа хийж, зээлийнхээ үлдэгдлийг хууль, журамд заасны дагуу ангилж, харгалзах эрсдэлийн сан байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ

28 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт

28.1.Банкны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, банк, эрх бүхий хуулийн этгээдийн шилжүүлгийн үйл ажиллагаанд Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

30.1.Энэ хуулийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР